

ОЮУ ТОЛГОЙ КОМПАНЫ УУРХАЙН ХАШААЛСАН ТАЛБАЙД ТҮР ХУГАЦААГААР МАЛ БЭЛЧЭЭРЛҮҮЛЭХ ЖУРАМ

Зорилго

Энэхүү журмыг Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй Оюу толгой ХХК-ны уурхайн үйлдвэрлэлийн хашаалсан талбайн тодорхой хэсэгт мал бэлчээрлүүлэхэд Орон нутгийн удирдлага, Малчид болон Оюу Толгой ХХК зэрэг талуудын хамтран ажиллахтай холбогдох харилцааг зохицуулахад баримтална.

НЭГ. Ерөнхий зүйл

- 1.1 Оюу Толгой ХХК нь уурхайн хашаалсан талбай болон түүний аливаа өргөтгөлийг ашиглах эрхийг дангаар эдэлнэ.
- 1.2 Оюу Толгой ХХК-ны уурхайн үйл ажиллагаа, эрүүл мэнд, аюулгүй байдал болон байгаль орчинтой холбогдсон шалтгааны улмаас энэхүү журмыг нэн даруй хүчингүй болгох эрхтэй байна.
- 1.3 Уурхайн хашаалсан талбайн зөвхөн тодорхой хэсэгт л мал оруулах боломжтой бөгөөд энэхүү талбайг Хавсралт-1-д тоймлон үзүүлсэн болно (цаашид Ургамлын бүрхэвчтэй талбай гэх). Ургамлын бүрхэвчтэй талбайг жил бүр хянан үзэж хамрах талбайн хэмжээг өөрчлөн тогтоож болох бөгөөд түүнийг талуудад танилцуулна.
- 1.4 Малыг аюулгүй бэлчээх боломжтой талбай (цаашид Мал бэлчээх боломжтой талбай гэх) нь Ургамлын бүрхэвчтэй талбайн хязгаар дотор байх бөгөөд энэ зөвхөн энэ талбайд жил бүрийн 4-р сарын 1-ээс 6-р сарын 1 хүртэл хүртэлх хугацаанд мал бэлчээх боломжийг олгоно.
- 1.5 Мал бэлчээх боломжтой талбайд малаа бэлчээх малчдын нэрсийг эцэслэн тогтоох нь сумын захиргааны шийдвэр байх бөгөөд малчны хүсэлт, цаг агаарын нөхцөл байдал болон Уурхайн талбайд хийсэн ургамлан бүрхэвчийн үнэлгээний дүгнэлт зэргийг үндэс болгоно.
- 1.6 Уурхайн талбайд мал бэлчээрлүүлэх шийдвэрийг үндэслэн талууд түр хугацааны санамж бичиг үйлдэх ба санамж бичигт бэлчээх малын тоо, хугацаа зэргийг тусгаж өгнө. Бэлчээх малын тоо, бэлчээрлүүлэх хугацаа зэргийг тогтоохдоо тогтсон талбайн ургамалын бүрхэвчийн тэжээлийн нөөцийг үндэс болгоно.
- 1.7 Малчдын хүсэлт болон бусад шалтгааны улмаас мал бэлчээх хугацааг өөрчлөх шаардлага гарч болох бөгөөд өөрчлөгдсөн хугацаа эхлэхээс наад зах нь 1 долоо хоногийн өмнө энэ тухай хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 1.8 Уурхайн талбай дахь аюулгүйн ажиллагааг хангах үүднээс адуунаас бусад малыг уурхайн хашаан доторх бэлчээрт оруулахыг зөвшөөрнө.

ХОЁР. Оюу толгой ХХК-ны үүрэг

- 2.1 Уурхайн үйлдвэрлэлийн талбайд хамаарах ургамлын бүрхэвчтэй талбайг хянан үзэж тэжээлийн нөөцийг тодорхойлон мал бэлчээрлүүлэх боломжтой эсэх болон бэлчээрийн нөөцтэй талбайн хэмжээг тогтоож, уг дүгнэлтийг 3 сарын 15-с өмнө талуудад танилцуулна.
- 2.2 Хавсралт 1-д тэмдэглэсэн байршилд (цаашид гарц байх цэгүүд гэх) буюу уурхайн талбайн хашааны тодорхой цэгүүдэд гарц бий болгох ба гарцуудыг хэзээнээс эхлэн ямар хугацаанд нээхийг малчдад танилцуулна.
- 2.3 Тухайн гарцыг энэхүү журмын дагуу тодорхойлсон мал бэлчээх хугацаанаас бусад хугацаанд хаалттай, түгжээтэй байлгана.

2.4 Мал бэлчээх хугацааны турш Оюу толгой ХХК нь түр хугацаагаар хоёр усны сав байршуулж, хөвөгч хавхлага бүхий онгоцыг өдөр бүр усаар дүүргэж байна.

ГУРАВ. Орон нутгын захиргааны үүрэг/ Сумын ЗДТГ/

- 3.1 Уурхайн талбайд малаа бэлчээх малчдын хүсэлтийг хянан үзэж уурхайн талбайд тухайн жилд малаа бэлчээх малчдын нэрсийг эцэслэн тогтоож 3 сарын 25-ны дотор Оюу толгой ХХК-ны Бүсийн хөгжил, Нийгмийн хэлтэст хүргүүлнэ.
- 3.2 Уурхайн талбайд малаа бэлчээх малчдыг мал бэлчээрлүүлэх хугацаанд шаардлагатай сургалтанд хамруулах, Оюу толгой ХХК-ны холбогдох дүрэм журмыг дагаж мөрдөх үүрэг чиглэлийг малчдад өгч, хянаж ажиллана.

ДӨРӨВ. Уурхайн талбайд малаа бэлчээрлүүлэх малчдын үүрэг

- 4.1 Малчид уурхайн талбайд малаа бэлчээх хүсэлтээ жил бүрийн 3-р сарын 10-ны дотор Орон нутгийн захиргаанд бичгээр уламжилна.
- 4.2 Орон нутгийн захиргааны шийдвэрээр уурхайн талбайд малаа бэлчээрлүүлэхээр зөвшөөрөгдсөн малчид Оюу толгой ХХК-тай хамтын ажиллагааны санамж бичиг үйлдэнэ.
- 4.3 Малаа уурхайн талбайд бэлчээрлүүлэхээр сонгогдсон малчид нь уурхайн талбайн аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамрагдаж, уурхайн талбайд түр нэвтрэх үнэмлэх авсан байх бөгөөд өглөө бүр зөвшөөрөгдсөн хаалгаар малаа бэлчээрт оруулаад орой бүр тогтсон цагт талбайгаас гаргаж байна.
- 4.4 Малчид нь мал бэлчээх хугацаанд малаа бүрэн хариуцан маллах ба энэ хугацаанд уурхайн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байх ба аливаа эвдрэл, доголдол гарвал уурхайн талбайн хамгаалалтын албанд цаг алдалгүй мэдэгдэнэ.
- 4.5 Малчид мал бэлчээх хугацааны турш зөвхөн тогтоосон талбайд малаа бэлчээрлүүлэх бөгөөд малаа уурхайн бусад хэсэгт нэвтрүүлэхгүй байх үүрэг хүлээнэ. Хэрэв бусад хэсэгт нэвтрүүлбэл үүдэн гарах хохирол, хариуцлагыг бүрэн хариуцна.
- 4.6 Ямар ч тохиолдолд уурхайн бусад хэсэгт өөрөө дур мэдэн нэвтрэхгүй байх үүрэг хүлээх бөгөөд тогтоосон талбайгаас мал гарч уурхайн бусад хэсэгт нэвтэрсэн тохиолдолд Оюу толгой ХХК-ны орон нутгийн харилцааны болон аюулгүй байдлын ажилтнуудад цаг алдалгүй мэдэгдэх ба компаний ажилтны хяналтын доор малаа нэн даруй эргүүлэн гаргана.
- 4.7 Малчид Оюу толгой ХХК -ны холбогдох дүрэм журмыг дагаж хэрэгжүүлэхийн зэрэгцээ Орон нутгийн дэмжлэг, түншлэл хариуцсан менежер болон Аюулгүй байдал хариуцсан менежерээс тухайн үеийн нөхцөл байдалаас шалтгаалан өгсөн аливаа зөвлөгөө чиглэлийг мал бэлчээх хугацаанд даган биелүүлнэ. Үүнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас шалтгаалан мал бэлчээх хугацаанд малыг төслийн талбайн хашаанаас гаргах хүсэлт, шаардлага багтаж болно.
- 4.8 Мал бэлчээх хугацаа дуусгавар болоход Малчид мал бэлчээх боломжтой талбайгаас бүх малаа гаргасан тухай НХ-ны хэлтэст бичгээр мэдэгдэнэ. Бүх малыг төслийн талбайн хашаанаас гаргамагц гарцуудыг хааж цоожилно.
- 4.9 Уурхайн хашаан доторх бэлчээрт бэлчиж буй зэрлэг ан амьтныг үргээхгүй, цочоохгүй, агнахгүй, хайрлаж хамгаалах үүрэгтэй.

ТАВ. Хүчин төгөлдөр байдал

- 5.1 Энэхүү журмыг 2015 оны 3 сарын 20-ний өдрийн Ханбогд сумын орон нутгийн удирдлага, Малчдын төлөөлөл, Оюу толгой ХХК-ийн төлөөлөл оролцсон уулзалт хэлэлцүүлгийн үеэр харилцан тохиролцсоны дагуу энэ өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**Ханбогд сумын орон нутгийн удирдлага, Малчдын төлөөлөл, Оюу толгой ХХК-ны
төлөөлөл**